



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/413

Улаанбаатар хот

Нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Газрын тухай" хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 56 дугаар зүйлийн 56.5, 57 дугаар зүйлийн 57.3, 57.4, 59 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дахь зүйл, нийслэлийн Засаг даргын 2019 оны А/322, дүүргийн Засаг даргын 2019 оны А/247, Б/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 14 дүгээр хороо, орон сууцны 20 дугаар байрны баруун хойно зөвшөөрөлгүй байрлуулсан 40 м.кв үйлчилгээний цэгийг албадан нүүлгэж нийтийн эзэмшил зам талбайг чөлөөлсүгэй.

2. Нийтийн эзэмшил зам талбайг чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажиллахыг Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Э.Сансар/, Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Нарангэрэл/, Газар зохион байгуулалтын алба /Г.Мөнхбаатар/, Замын цагдаагийн хэлтэс /цагдаагийн хурандаа Ц.Ариунболд/, Баянгол Шинэ Өргөө ОНӨҮГ /Б.Мөнгөнсүх/, 14 дүгээр хорооны Засаг дарга /Р.Батнасан/ нарт тус тус даалгасугай.

3. Гарсан зардлыг Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх заалтын дагуу гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлсүгэй.

4. Төрийн байгууллагын үйл ажиллагааг саадгүй явуулах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс /цагдаагийн хурандаа Б.Буянтөр/, Онцгой байдлын хэлтэс /дэд хурандаа Б.Сүхбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



СОДОНТУЯА